МЭДЭЭ · 2026 оны 9-р сарын 28

САНХҮҮГИЙН БАРИМТ ХУУРАМЧААР ҮҮСГЭЖ, УРАМШУУЛАЛ АВСАН ХЭРГИЙГ ШҮҮХЭД ШИЛЖҮҮЛЛЭЭ



Прокурорын байгууллага 2026 оны 9 дүгээр сарын 21-ний өдрөөс 25-ны өдрийг хүртэлх хугацаанд хэрэг бүртгэлт, мөрдөн байцаалтын 44,815 эрүүгийн хэрэгт хяналт тавин ажиллажээ.

Дээрх хугацаанд 1,381 гэмт хэргийн шинжтэй гомдол, мэдээлэл бүртгэгдсэн бол хэрэг бүртгэлтийн 799 хэрэг шинээр нээж, 256 хэрэгт прокурор яллах дүгнэлт үйлдсэн байна.

Яллах дүгнэлт үйлдсэн хэргийг тодруулбал, Хүний эрүүл мэндийн халдашгүй байдлын эсрэг 95, Хөдөлгөөний аюулгүй байдал, тээврийн хэрэгслийн ашиглалтын журмын эсрэг 71, Өмчлөх эрхийн эсрэг 59, Хүрээлэн байгаа орчны эсрэг 11, Олон нийтийн аюулгүй байдал, ашиг сонирхлын эсрэг 5, Авлигын эсрэг болон Эдийн засгийн гэмт хэрэг тус бүр 4, Хүний амьд явах эрхийн эсрэг 3, Хүний халдашгүй, чөлөөтэй байх эрхийн эсрэг гэмт хэрэг болон Кибер аюулгүй байдлын эсрэг гэмт хэрэг тус бүр 2 яллах дүгнэлт үйлдсэн байна.



Нийслэлийн прокурорын газраас яллах дүгнэлт үйлдэн шүүхэд шилжүүлсэн хэргүүдийг тоймлон хүргэвэл:

Авлигын хэргийн талаар:

- Б.С нь Монголын үндэсний музейн захирлаар, Д.Б нь санхүүгийн хэлтсийн даргаар ажиллаж байхдаа бүлэглэн “Н...” ХХК-тай 2025 оны 2 дугаар сарын 07-ны өдөр аялал жуулчлалын гэрээ байгуулж, БНХАУ-ын Санъяа хотын шууд нислэгтэй аялалд өөрсдийн хамаарал бүхий хүмүүс болон музейн ажилчид болох нийт 40 хүний бүрэлдэхүүнтэй аяллыг зохион байгуулж, гэрээний төлбөрийг хийхдээ “Музейн ваучерийн үйлчилгээний гэрээ”-ний дагуу музейн орлогод орох байсан төлбөрийг бартер байдлаар тохиролцож, бусдад давуу байдал бий болгож, Монголын үндэсний музейд 44.8 сая төгрөгийн хохирол учруулсан хэрэгт Эрүүгийн хуулийн 22.1 дүгээр зүйлийн 1 дэх хэсэг (Эрх мэдэл, албан тушаалын байдлаа урвуулах)-т зааснаар яллах дүгнэлт үйлдэж, Дүүргийн Эрүү, Иргэний хэргийн хялбар ажиллагааны анхан шатны тойргийн шүүхэд;

- Н.Б нь улс төрд нөлөө бүхий этгээд буюу Монголбанкны ерөнхийлөгчөөр ажиллаж байхдаа “К... “ банканд томилогдсон банкны эрх хүлээн авагчийн зөвлөлийн гишүүдтэй “К... банканд томилогдсон банкны эрх хүлээн авагчийн ажиллах гэрээ”-г байгуулж, бусдад давуу байдал бий болгож, “К...” ХХК-д 1.4 тэрбум төгрөгийн хохирол учруулсан,

Мөн тус банк нь харилцагч, хадгаламж эзэмшигч нарын анхны шаардлагаар төлбөр түргэн гүйцэтгэх чадваргүй болсон, 2015.01.01-нээс 2019.04.08-ны өдрийг хүртэлх хугацаанд Монголбанк руу 111 удаа заавал байлгах нөөцийн тайлан явуулж, улмаар төгрөгийн болон валютын заавал байх нөөцийн хувь хэмжээг хангаж ажиллаагүй байхад нь санхүүгийн байдлыг нь сайжруулж, алдагдлыг багасгах зорилгоор

удирдлага, зохион байгуулалтын арга хэмжээ авах, банкийг албадан татан буулгах бүрэн эрхээ зориуд хэрэгжүүлэхгүй удаашруулж “К...” ХХК-д давуу байдал бий болгосон хэрэгт Эрүүгийн хуулийн 22.1 дүгээр зүйлийн 3 дахь хэсэг (улс төрд нөлөө бүхий этгээд эрх мэдэл, албан тушаалын байдлаа урвуулах)-т зааснаар яллах дүгнэлт үйлдэж, Баянзүрх, Сүхбаатар, Чингэлтэй дүүргийн Эрүүгийн хэргийн анхан шатны тойргийн шүүхэд;

Мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодис хууль бусаар ашиглах хэргийн талаар:

- Г.Г нь 2024 оны 5 дугаар сарын 19-ний өдөр Сонгинохайрхан дүүргийн нутаг дэвсгэрээс метамфетамины агууламжтай, "мөс”, "өвс” гэх хэрэглээний нэршилтэй хориглосон сэтгэцэд нөлөөд бодисуудыг тус тус худалдаалах зорилгогүйгээр хууль бусаар олж авсан, улмаар өөрийн биедээ хадгалсан,

- Б.Б нь морфин (morphine) гэх нэршилтэй хориглосон мансууруулах эм, мөн “дроп” гэх хэрэглээний нэршилтэй, MDMB-4en-PINACA, 5F-MDMB-PINACA (5F-ADB), 4F-MDMB-BINACA-ын агууламжтай, хориглосон сэтгэцэд нөлөөт бодисуудыг хууль бусаар олж авсан, улмаар 2026 оны 3 дугаар сарын 23-ны өдрийг хүртэлх хугацаандтээврийн хэрэгсэлдээ хадгалсан хэрэгт тус тус Эрүүгийн хуулийн 20.7 дугаар зүйлийн 1 дэх хэсэг (Мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодисыг хууль бусаар ашиглах)-т зааснаар яллах дүгнэлт үйлдэж, Баянгол, Хан-Уул, Сонгинохайрхан дүүргийн Эрүүгийн хэргийн анхан шатны тойргийн шүүхэд,

- Б.Т нь 2024 оны 7 дугаар сарын 06-ны өдөр Налайх дүүргийн нутаг дэвсгэрт Playtime арга хэмжээний үед "өвс" гэх хэрэглээний нэршилтэй, дельта-9 тетрагидроканнабинол (delta-9 tetrahydrocannabinol) бодисын агууламжтай, хориглосон сэтгэцэд нөлөөт бодисыг худалдаалах зорилгогүйгээр хууль бусаар олж авсан хэрэгт Эрүүгийн хуулийн 20.7 дугаар зүйлийн 1 дэх хэсэг (Мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодисыг хууль бусаар ашиглах)-т зааснаар яллах дүгнэлт үйлдэж, Багахангай, Налайх дүүргийн Эрүүгийн хэргийн анхан шатны тойргийн шүүхэд;

Бусад хэргийн талаар:

- БНХАУ-ын иргэн В... П..., Монгол Улсын иргэн С.Х нар нь бүлэглэн 2023 оны 4 дүгээр сараас 2024 оны 04 дүгээр сар хүртэлх хугацаанд Баянзүрх дүүргийн нутаг дэвсгэрт байрлах О...зочид буудлын караокед нэр бүхий 10 эмэгтэйг эмзэг байдлыг нь ашиглан, гадаад улсын иргэдэд дуу дуулах, архи хундагалуулан биеийг нь үнэлүүлж, бие үнэлэхийг зохион байгуулсан, орон байраар хангасан,

Мөн С.Х, Ц.Х нар нь бүлэглэн 2025 оны 2 дугаар сарын 09-ний өдөр нэр бүхий иргэнийг бусдад биеэ үнэлэхэд нь зуучилсан хэрэгт Эрүүгийн хуулийн 12.6 дугаар зүйлийн 1;2 дахь хэсэг (Биеэ үнэлэхийг зохион байгуулах)-т зааснаар яллах дүгнэлт үйлдэж, Баянзүрх, Сүхбаатар, Чингэлтэй дүүргийн Эрүүгийн хэргийн анхан шатны тойргийн шүүхэд,

- Б.У нь Сэлэнгэ аймгийн нутаг дэвсгэрт тариалангийн үйлдвэрлэл эрхэлж байхдаа 2024 оны 8 дугаар сарын 20-ноос 2024 оны 10 дугаар сарын 23-ны өдрийн хооронд

нийт 459 сая төгрөгийн борлуулалт хийсэн мэтээр санхүүгийн анхан шатны баримт болох и-баримтыг хуурамчаар үүсгэж, түүнийгээ ашиглаж Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн сайд, Сангийн сайдын 2022 оны А/218/А/146 дугаар хамтарсан тушаалаар батлагдсан "Тариалангийн үйлдвэрлэл эрхэлж байгаа иргэн, хуулийн этгээдийн үйлдвэрлэсэн бүтээгдэхүүнд мөнгөн урамшуулал олгох, мөнгөн бус дэмжлэг үзүүлэх журам"-д заасан хүнсний ногооны урамшуулалд хамрагдаж нийт 316.2 сая төгрөгийг хууль бусаар авсан хэрэгт Эрүүгийн хуулийн 18.7 дугаар зүйлийн 1 дэх хэсэг (Мөнгөн тэмдэгт, үнэт цаас, төлбөр тооцооны хэрэгсэл хуурамчаар бэлтгэх, ашиглах)-т зааснаар яллах дүгнэлт үйлдэж, Сэлэнгэ аймгийн Сайхан сум дахь сум дундын шүүхэд тус тус шилжүүлсэн байна.

Эх сурвалж: https://prosecutor.mn/post/403